



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025. 09. 10 № 2675
танай 2025. 08. 26 -ны № 33 -т

Хариу хүргүүлэх тухай

Таны 2025 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн “Эдийн засгийн хараат бус хяналтын хэрэгжилтийн талаар” ирүүлсэн 33 дугаартай асуулттай танилцлаа.

Төрийн аудитын байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүрэг, хараат бус байдал, аудитын үр нөлөө болон төрийн санхүү, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалтын зохистой байдалтай холбоотой чухал асуудлууд байгаад талархаж байна.

Таны асуултад холбогдох танилцуулга, мэдээллийг хавсралтаар хүргүүлж байгааг хүлээн авна уу.

Хавсралт ... хуудастай.



С. МАГНАЙСҮРЭН

Монгол Улсын Ерөнхий аудиторовын
2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн
2675 дугаар албан бичгийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ АСУУЛТАД ХОЛБОГДОХ ТАНИЛЦУУЛГА, МЭДЭЭЛЭЛ

Нэг.Үндсэн хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийн түвшин, үр дүнтэй хэрэгжүүлэхэд саад учруулж буй асуудлын талаар

Нэгдсэн Үндэстний Байгууллага болон түүний төрөлжсөн байгууллагуудад гишүүнчлэл бүхий дэлхийн 196 орныг эгнээндээ нэгтгэсэн аудитын дээд байгууллагуудын мэргэжлийн байгууллага ИНТОСАИ, 48 орны гишүүнчлэлтэй Аудитын дээд байгууллагуудын Азийн байгууллага АСОСАИ-д Монгол Улсын Үндэсний аудитын газар 1996 онд бүрэн эрхт гишүүнээр элссэн.

ИНТОСАИ, АСОСАИ-н гишүүн байгууллагууд нь Аудитын дээд байгууллагуудын хараат бус байдлын тухай Лимагийн болон Мексикийн тунхаглалыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг хангах үүргийг хүлээдэг. Эдгээр тунхаглалуудын гол зорилго нь хараат бус төрийн аудитыг бүрдүүлэх, “Энэ шаардлагыг хангахгүй Аудитын дээд байгууллага стандартад үл нийцнэ” гэж үздэг бөгөөд Аудитын дээд байгууллага зөвхөн хараат бус байдлыг олж авснаар биелэгдэхгүй, энэ хараат бус байдал нь дотоодын хууль тогтоомжоор баталгаажсан байхыг шаарддаг.

Мөн төсвийн хөрөнгө болон нөөцийг дэг журамтай, үр ашигтай ашиглах, улсын санхүүг зөв зүйтэй удирдах, эрх бүхий этгээдийн шийдвэрийг үр нөлөөтэй байлгахад чухал үүрэг гүйцэтгэгч нь Аудитын дээд байгууллага гэж үздэг учраас улс орны эдийн засгийн удирдлагын өнөөгийн нөхцөл байдлыг олон улсын түвшинд үнэлүүлэхэд онцгой ач холбогдолтой хөндлөнгийн буюу түншийн үнэлгээг Аудитын дээд байгууллагууд хийлгэж, үйл ажиллагаагаа илүү сайжруулах чиглэлээр ажилладаг.

2010 онд Норвеги Улсын Ерөнхий аудиторовын газрын дэмжлэгтэйгээр Швед Улсын Үндэсний аудитын газраас гүйцэтгэлийн аудитын тогтолцоо болон үйл ажиллагаанд, 2016 онд Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Үндэсний аудитын газраас Монгол Улсын Үндэсний аудитын газрын санхүүгийн аудитын үйл ажиллагаанд тус тус хөндлөнгийн буюу түншийн үнэлгээ хийгдсэн. Эдгээр түншийн үнэлгээгээр Монгол Улсын Үндсэн хуульд Төрийн аудитын байгууллагын тогтолцооны талаар зохицуулалт байхгүй, Төрийн аудитын тухай хууль (2003 он)-д санхүүгийн болон байгууллагын хараат бус байдлын талаар тодорхой хэмжээний зохицуулалт байсан ч Үндсэн хуулийн зохицуулалтгүй байгаа нь энэ хараат бус байдалд нөлөөлөх эрсдэлтэй байна гэж дүгнэгдсэн.

Төрийн аудитын байгууллага нь ИНТОСАИ, АСОСАИ-н гишүүний хувьд Лимагийн болон Мексикийн тунхаглалыг мөрдөхийн зэрэгцээ, түншийн үнэлгээгээр өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагын дагуу Монгол Улсын Үндсэн хуульд төрийн аудитын байгууллагын хараат бус байдлын талаарх зохицуулалтыг тусгуулахаар Улсын Их Хуралд удаа дараагийн хүсэлтийг уламжилж байсан.

Улмаар 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтад “Төрийн санхүү, төсвийн хяналтын хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” гэсэн заалт нэмсэн.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн агуулга, үзэл санаанд холбогдох хууль тогтоомжийг нийцүүлж, эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд Улсын Их Хурлаас 2020 оны 02 дугаар “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” тогтоолыг баталсан. Тус тогтоолын хавсралтын 1.2.5-д “төрийн санхүү, төсвийн хяналт /аудит/-ыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтоох;”, 1.2.6-д “төрийн нийтийн өмчийг зохистой ашиглах, зарцуулахад тавих хяналтыг боловсронгуй болгох.” гэсэн үзэл баримтлалын чиглэлүүдийг тусгасан.

Дээрх үзэл баримтлалын хүрээнд Төрийн аудитын тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2020 оны 05 дугаар сарын 01-ний өдөр батлагдаж, мөн оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалын дагуу төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллага нь төрийн аудитын байгууллага байна.” гэж заасан.

Төрийн аудитын үндсэн зорилт нь төрийн санхүү, төсөв, нийтийн өмчийг хууль ёсны дагуу арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулахад хяналт тавих, түүнчлэн төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулж, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэхэд чиглэдэг. Энэхүү зорилтын хүрээнд төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэн, өнөөгийн байдлаар Төрийн аудитын байгууллага улсын хэмжээнд санхүүгийн тайлангийн аудитад 6800 орчим байгууллагыг, гүйцэтгэл, нийцлийн аудитад 7100 (давхардсан тоогоор) гаруй байгууллагыг хамруулан аудит хийж байна.

Тодруулбал, Төрийн аудитын байгууллага нь “төрийн санхүү, төсвийн хяналт” буюу төрийн санхүү, төсөв, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, эргэн төлөгдөх нөхцөлөөр ашиглуулах үйл ажиллагаа, хувьчлал, дуудлага худалдаа, техник, эдийн засгийн үндэслэл, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа, зээллэг, гадаад зээл, тусламж, хандив, санхүүгийн дэмжлэг, өрийн баталгаа, үнэт цаас, бүх төрлийн гэрээ, хэлцэл болон бусад аливаа үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, ашиглалт, зарцуулалт, хэрэгжилт, тайлагнал болон нийтийн өмчтэй холбоотой бүх үйл ажиллагаанд төрийн аудит хийх чиг үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн аудитын тухай хуулиар хүлээж байна.

Жил бүр гүйцэтгэх аудитын сэдвийг Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Монгол Улсын Ерөнхий аудитор аудитын сэдвийг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд танилцуулж, шийдвэрлүүлнэ” гэж заасны дагуу Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороогоор хэлэлцүүлэн, тогтоолоор батлуулсны үндсэн дээр гүйцэтгэж байна.

Төрийн аудитын байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилттэй холбоотой үйл ажиллагааны гол үзүүлэлтийг сүүлийн таван жилийн байдлаар дараах хүснэгтээр харуулж байна.

Хүснэгт 1. Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны үзүүлэлт

Үзүүлэлт		2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
Төлөвлөсөн аудитын тоо		4,171	4,171	4,292	4,137	3,821
Гүйцэтгэсэн аудитын тоо		4,141	4,134	4,284	4,134	3,823
Аудитын илрүүлэлт						
Тоо		22,543	21,794	24,833	28,213	24,193
Дүн /сая төгрөг/		12,848,671.8	10,091,094.1	13,479,861.4	24,439,310.1	46,365,379.8
Төлбөрийн акт						
Тайлант онд өгсөн	Тоо	1,934	2,012	2,038	2,737	2,418
	Дүн /сая төгрөг/	43,051.2	59,662.1	160,881.9	242,216.8	76,343.7
Хэрэгжилт	Тоо	1,669	1,695	1,718	2,276	2,136

	Дүн /сая төгрөг/	17,940.9	53,753.3	69,593.8	35,750.6	11,960.7
Албан шаардлага						
Тайлант онд өгсөн	Тоо	3,313	4,948	6,959	6,734	6,389
	Дүн /сая төгрөг/	2,297,611.1	2,211,040.2	5,864,896.0	6,328,402.3	33,319,663.9
Хэрэгжилт	Тоо	2,851	4,233	5,707	5,276	4,723
	Дүн /сая төгрөг/	421,899.0	1,283,983.4	2,634,352.8	2,215,591.0	1,365,833.1
Зөвлөмж						
Тайлант онд өгсөн	Тоо	9,890	10,009	10,235	9,949	9,629
	Дүн /сая төгрөг/	3,837,982.1	3,627,908.7	4,636,270.6	5,777,576.8	7,355,622.0
Хэрэгжилт	Тоо	8,652	8,461	8,585	8,301	7,245
	Дүн /сая төгрөг/	2,917,827.9	573,982.3	1,815,306.8	714,819.0	880,718.3
Албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал						
Тайлант онд шинээр шилжүүлсэн, Үүнээс:		519	176	342	355	315
Бүрэн хэрэгжсэн		560	202	331	262	257
Хэрэгжээгүй		102	24	35	106	94
Хүлээн зөвшөөрүүлсэн үр өгөөж						
Санхүүгийн	Тоо	4,170	4,163	3,888	4,949	4,313
	Дүн /сая төгрөг/	293,777.8	757,305.8	1,244,896.0	1,097,900.5	1,730,511.3
Санхүүгийн бус		1,269	2,265	1,445	1,036	1,053
Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн орлого						
Дүн /сая төгрөг/		40,050.2	53,128.4	41,425.6	51,806.4	43,735.9
Нэг төгрөгт ногдох үр өгөөж /төгрөг/		19	53	41	38	41
Залруулсан алдаа /тэрбум төгрөг/		4,653.7	4,179.9	2,401.9	6,775.7	5,109.3

Аудитын шийдвэрийг хэрэгжүүлэхэд хууль, эрх зүйн орчны тодорхойгүй байдал:

Төрийн аудитын тухай хуульд “шалгагдагч этгээд” гэж төсвийн байгууллага, тусгай сан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төрийн чиг үүргийг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээд болон хуульд заасны дагуу төрийн аудит хийгдэх аливаа этгээдийг ойлгохоор тодорхойлсон.

Төрийн аудитын байгууллага аудитын дүн, дүгнэлтэд тулгуурлан төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулах зорилгоор шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтанд зөвлөмж, албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох зэрэг хуульд заасан шийдвэрлэлтийг хийж, аудитын тайланг Улсын Их Хурал, холбогдох Байнгын хороодод хүргүүлэн хэлэлцүүлдэг.

Төрийн аудитын байгууллагаас Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэсэн аудитаар шалгагдагч этгээд хууль тогтоомж, эрх зүйн акт зөрчсөн, гэрээ, хэлэлцээрийг холбогдох хууль, журамд нийцүүлж ажиллаагүй зэрэг илэрсэн зөрчилд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь хэсэгт заасны дагуу төлбөрийн акт тогтоож, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар албан тушаалтанд албан шаардлага өгч ажилладаг. Гэвч зарим тохиолдолд хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг холбогдох этгээд хэрэгжүүлэхгүй байх хүндрэл бэрхшээл үүсдэг.

Төрийн аудитын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д “Төрийн аудитын байгууллага хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг Захиргааны ерөнхий хуулийн 82, 83 дугаар зүйлд заасан журмаар гүйцэтгэнэ.” гэж, Захиргааны ерөнхий хуулийн 82-91 дүгээр зүйлүүдэд захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар болон захиргааны актыг батлан гаргасан захиргааны байгууллага шийдвэрээ гүйцэтгэх талаар тус тус зохицуулсан.

Мөн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 136 дугаар зүйлд шүүхийн шийдвэр гүйцэтгэх үндэслэлийг шүүхийн шийдвэр болон түүний үндсэн дээр олгогдох гүйцэтгэх хуудас байна гэж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 183 дугаар зүйлийн 183.1-д "...улсын байцаагчийн төлбөр тогтоосон акт, тэдгээрийн үндсэн дээр олгогдсон гүйцэтгэх хуудас байна." гэж тус тус хуульчилсан.

Төрийн аудитын байгууллагаас тогтоосон боловч биелээгүй, хүчин төгөлдөр төлбөрийн акт, албан шаардлагад гүйцэтгэх хуудас бичигдэхгүй байгаа нь албадлага хэрэглэх боломжгүй нөхцөл байдлыг үүсгэн төрийн санхүү, төсвийн хяналт үр дүнгүй болох, улмаар төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой илэрсэн зөрчилд хийсэн аудитын шийдвэр болох албан шаардлага, төлбөрийн акт биелэхгүй байх нөхцөл үүсээд байна.

Төрийн аудитын байгууллага үйл ажиллагаагаа хараат бус хэрэгжүүлэх эдийн засгийн баталгааны талаар:

Лимагийн тунхаглал (Зүйл 7. Аудитын дээд байгууллагын санхүүгийн хараат бус байдал)-д "Аудитын дээд байгууллага ажил үүргээ хэрэгжүүлэх боломж олгохуйц санхүүгийн хөрөнгөөр хангагдана." гэж, Төрийн аудитын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1-д "Төрийн аудитын байгууллага улсын төсвөөс санхүүжнэ. Төрийн аудитын байгууллага үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх эдийн засгийн баталгааг төр хангана.", 40.2-т "Монгол Улсын Ерөнхий аудитор төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөн Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд хянуулахаар хүргүүлнэ.", 40.3-т "Монгол Улсын Ерөнхий аудитор Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороогоор хянагдсан төрийн аудитын байгууллагын төсвийн төслийн эцсийн хувилбарыг улсын төсөвт нэгтгүүлэхээр санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хуульд заасны дагуу хүргүүлнэ.", 40.4-т "Засгийн газар төрийн аудитын байгууллагын төсвийн төслийг бууруулахгүйгээр улсын төсвийн төсөлд тусгаж Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ." гэж тус тус заасан Төрийн аудитын байгууллага хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх эдийн засгийн баталгааны талаар хуульчлан зохицуулсан.

Хуулийн дээрх зохицуулалт бодит байдалд хэрэгжихгүй, санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (шалгагдагч этгээд) Төрийн аудитын байгууллагын жилийн төсвийн хязгаарын саналыг хянаж, тодорхой хэмжээгээр бууруулан УИХ-аас шийдвэр гаргуулсаар байгаа билээ.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр ҮАГ-т хэрэгжүүлсэн "ТАБ-ын чадавхыг бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд Австралийн Үндэсний аудитын газар болон Бүгд найрамдах Индонез Улсын Аудитын зөвлөл хамтран 2023 онд хийсэн түншийн үнэлгээний тайланд:

- "...Төсвийн үйл явцын хүрээнд МУЕА нь Төрийн аудитын байгууллагын төсвийн төслийн эцсийн хувилбарыг ТБХ-гоор хянуулан хэлэлцүүлсний дараа Улсын төсөвт нэгтгүүлэхээр Сангийн яам (санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага)-нд өргөн мэдүүлдэг. Төрийн аудитын тухай хуульд ТБХ-гоор хянан хэлэлцэгдсэн төсвийн төслийг бууруулахгүйгээр улсын төсвийн төсөлд тусгаж УИХ-д өргөн мэдүүлнэ гэж заасан байдаг. Гэвч сүүлийн жилүүдэд Сангийн яам эдгээр заалтыг үл харгалзан ТАБ-ын төсвийг улсын төсөвт нэгтгэхдээ бууруулсан. Тухайлбал, Тус яам ТАБ-ын УИХ-ын ТБХ-ноос баталсан төсвийн төслийн дүнгээс 2020 онд 1.4 тэрбум, 2021 онд 2.0 тэрбум, 2022 онд 1.1 тэрбум, 2023 онд 2.6 тэрбум төгрөгөөр бууруулж, санхүүжилтийг УИХ-р баталсан байна. Дээрх хугацаанд ТАБ-ын батлагдсан жилийн төсөв болон МУЕА-ын анх мэдүүлсэн төсвийн санал хоорондын зөрүү (бууралт) 7-20%-ийн хооронд хэлбэлзэж байна.
- ...Төрийн аудитын тухай хууль болон Төсвийн тухай хуулийн бодит байдал дээрх хэрэгжилт нь ТАБ-ын санхүүгийн бие даасан байдлыг хангахад хязгаарлагдмал байна.
- ...Төсөв боловсруулах үйл явц дахь хөндлөнгийн харилцагч талуудын оролцоо нь ТАБ өөрт олгогдсон бүрэн эрхийн дагуу ажлаа төлөвлөж, хэрэгжүүлэхэд

шаардагдах хангалттай хөрөнгө нөөцтэй байх эсэхэд нөлөөлж болохоор байна.” гэж тусгажээ. Эндээс үзэхэд ТАБ-ын “санхүү”-гийн бүрэн бие даасан хараат бус байдлыг алдагдуулж ирснийг харуулж байна.

Төрийн аудитын тухай хуульд Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаагаа хэвийн явуулах эдийн засгийн баталгааг хуульчилсан боловч төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг төлөвлөж, зарцуулахаар тооцон Сангийн яаманд хүргүүлснийг 2022 онд 6.5 тэрбум төгрөгөөр, 2023 онд 2.6 тэрбум төгрөгөөр тус тус бууруулж, Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлж байсан.

2025 оны батлагдсан төсөв тодотголоор 5.97 тэрбум төгрөгөөр буурч тодотгосон дүнгээр 48.4 тэрбум төгрөгөөр батлагдсан. Тодотголоор хасагдсан зардлын дийлэнхийг үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардагдах зардлууд эзэлж байна. Тодруулбал, цалин хөлсний зардлыг 2,081,807.4 сая төгрөгөөр, томилолтын зардлыг 493,723.2 сая төгрөгөөр, аудитад шинжээч оролцуулах ажлын зардлыг 662,143.4 сая төгрөгөөр гэх зэргээр тус тус бууруулсан.

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 05 дугаар тогтоолоор Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын сэдвийг баталсан бөгөөд хуулийн дагуу гүйцэтгэх 17, бодлогоор гүйцэтгэх 24 нийт 41 аудитын сэдвийн хүрээнд санхүүгийн тайлангийн аудитад 6800 гаруй байгууллагыг, гүйцэтгэл, нийцлийн аудитад 7100 (давхардсан тоогоор) гаруй байгууллагыг хамруулж аудитыг гүйцэтгэхээр ажиллаж байна.

Төрийн аудитын байгууллага цаг хугацаа, хүний нөөц, төсөв санхүүгийн хязгаарлагдмал байдалд хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх шаардлага тулгараад байгаа билээ.

Хоёр. Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын жилийн төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх, зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар өгсөн дүгнэлт, саналын хэрэгжилт, түүний учир шалтгаан, үр дагаврын талаар:

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргах аудитыг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэж байна.

Монгол Улсын 2022, 2023, 2024, 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт өгсөн аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг сүүлийн 4 жилийн байдлаар нэгтгэн дүгнэхэд дунджаар 71 хувийн гүйцэтгэлтэй байна. Улс болон орон нутгийн төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх, зардлыг бууруулах, төсвийн үр ашгийг дээшлүүлэх талаар өгсөн саналын хэрэгжилтийг доор үзүүлэв.

Хүснэгт 2. Төсвийн үр ашгийг дээшлүүлэхээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн
(тэрбум төгрөг)

Аудит хийсэн он	Аудитын нэр	Боловсруулсан санал				Хүлээн зөвшөөрөгдөж, төсөвт тусгасан санал			
		Орлого нэмэгдүүлэх		Зардал хорогдуулах, үр ашиг дээшлүүлэх		Орлого нэмэгдүүлэх		Зардал хорогдуулах, үр ашиг дээшлүүлэх	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

2021	Монгол Улсын болон орон нутгийн 2022 оны нэгдсэн төсвийн төсөлд өгсөн дүгнэлт	166	93.7	262	51.1	110	24.2	124	22.1
2022	Монгол Улсын болон орон нутгийн 2023 оны нэгдсэн төсвийн төсөлд өгсөн дүгнэлт	112	850.5	260	1,011.7	77	34.3	159	45.9
2023	Монгол Улсын болон орон нутгийн 2024 оны нэгдсэн төсвийн төсөлд өгсөн дүгнэлт	69	30.8	213	119.6	54	23.8	107	18.9
2024	Монгол Улсын болон орон нутгийн 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд өгсөн дүгнэлт	75	39.7	261	163.6	33	20.2	124	73.2
Нийт дүн		422	1,014.7	996	1,346.0	274	102.5	514	160.1

Төрийн аудитын байгууллагаас төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх талаар өгсөн саналаас 2021 онд 24.2 тэрбум, 2022 онд 34.3 тэрбум, 2023 онд 23.8 тэрбум, 2024 онд 20.2 тэрбум төгрөгийн саналыг дүгнэлтээр хүргүүлж, нийт 102.5 тэрбум төгрөгөөр төсвийн орлого нэмэгдүүлэх саналыг төсвийг хэлэлцүүлэх шатанд хүлээн авч биелсэн байна.

Мөн төсвийн зардлыг бууруулж, үр ашгийг дээшлүүлэх талаар 2021 онд 22.1 тэрбум, 2022 онд 45.9 тэрбум, 2023 онд 18.9 тэрбум, 2024 онд 73.2 тэрбум төгрөгийн саналыг хүргүүлж, нийт 160.1 тэрбум төгрөгийн төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх санал хэрэгжсэн байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт гаргах аудитаар өгсөн зарим зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, зөрчил дутагдал давтагдсан хэвээр байгаа нь аудитын дүгнэлтийн ач холбогдлыг бууруулж байна. Төсвийн төсөлд дүгнэлт өгсөн аудитын зарим зөвлөмж бүрэн хэрэгжээгүйгээс Засгийн газар болон холбогдох байгууллагуудад дараах эрсдэл бүхий асуудлуудыг толилуулж ирсэн. Тухайлбал,

- Монгол Улсын нэгдсэн төсвийн тухайн оны төсвийн хүрээний мэдэгдэл, дунд хугацааны төсвийн төсөөллийн тухай хуулийг төсөвт өөрчлөлт оруулах бүрд нэмж өөрчилж байгаа нь төсвийн удирдлагын зарчим, сахилга батыг алдагдуулж, дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн ач холбогдлыг бууруулдаг;
- Орлогыг ихэвчлэн өөдрөгөөр тооцсоноос төсвийн орлогын төлөвлөгөө биелэхгүй байх, гадаад хүчин зүйлийн нөлөөллөөс уул уурхайн салбарын голлох нэрийн бүтээгдэхүүний эрэлтээс шалтгаалж нүүрсний экспорт төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй тохиолдолд зарлагыг хэрхэн санхүүжүүлэх, төсвийн орлого тасрах эрсдэлийг дутуу тооцдог;
- Төсвийн төсөлд зураг төсөвгүй, төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг тусгадаг нь төсөл, арга хэмжээний гүйцэтгэл удааширч он дамжих, төсөвт өртөг нэмэгдэх, үр ашиг буурах, хуулийн хэрэгжилт хангагдахгүй зэрэг сөрөг үр дагаварт хүргэдэг;
- Төсвийн ерөнхийлөн захирагч нар төсвийн төслийг боловсруулахдаа хөтөлбөр бүрийн өртгийг тооцоогүй, арга хэмжээний хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг иж бүрэн тодорхойлохгүй байна.

Монгол Улсын төсвийн орлогын бүрдүүлэлт уул уурхайн салбараас ихээхэн хамаардаг бөгөөд гол нэрийн бүтээгдэхүүн болох нүүрсний экспортын хэмжээ, зах зээлийн үнийн хэлбэлзэл нь төсвийн төлөвлөлтийн чанар, гүйцэтгэлд нөлөөлж байна. Засгийн газар жил бүрийн төсвийн орлогыг өөдрөгөөр тооцож, түүнд нийцүүлэн төсвийн хүрээний

мэдэгдэл, дунд хугацааны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах нөхцөлийг бүрдүүлдэг.

Үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийг тодорхой салбараар, үе шаттайгаар нэвтрүүлэх төсвийн бодлогын цаг хугацааны үечлэл болон хөтөлбөрийн өртгийг тооцох, арга хэмжээний хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг тоон болон чанарын утгаар хэмжих арга аргачлалыг нарийвчлан тодорхойлж, төлөвлөлтийг сайжруулах ажил удаашралтай байна.

Төрийн аудитын байгууллагын зүгээс эдийн засгийн эмзэг байдлыг нэмэгдүүлсэн эрдэс, баялгийн үнэд суурилсан орлогын огцом өсөлтөөс зайлсхийж, төсвийн тогтвортой байдлыг хадгалах, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгох үзэл баримтлалыг жил бүрийн төсвийн урт, дунд хугацааны бодлогод тодорхойлж, хэрэгжүүлэх талаар бодлогын түвшинд анхаарч ажиллах талаарх зөвлөмжийг нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар тухай бүр толилуулж ирсэн.

Төрийн аудитын байгууллагаас жил бүр Засгийн газрын газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийж, тайлан дүгнэлтийг УИХ болон холбогдох бүх байнгын хорооны хуралдаанаар үе шаттайгаар хэлэлцүүлж байна. Тухайлбал, Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1*-д заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2** дахь заалтын дагуу аудит хийсэн. Аудитын зорилтыг Монгол Улсын 2023 оны нэгдсэн төсвийн зорилт үр нөлөөтэй хэрэгжсэн, төсвийн гүйцэтгэлийг үнэн зөв илэрхийлсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, дүнг УИХ-д танилцуулсан. Нийт 6599 төсөвт байгууллага, сангуудын төсвийн гүйцэтгэлийн тайланг аудитад хамруулсан. Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн УИХ-д 4 асуудлыг толилуулж, Ерөнхий сайдад 14, Эдийн засгийн хөгжлийн сайдад 2, Сангийн сайдад 15, холбогдох бусад сайд, Төсвийн ерөнхийлөн захирагч нарт 9 зөвлөмжийг тус тус хүргүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нийт 6,916 байгууллагыг нэгтгэсэн санхүүгийн тайланд УСНББОУС, СТОУС, санхүүгийн тайлагналын үзэл баримтлалд нийцүүлэн үнэн зөв илэрхийлсэн эсэхэд "Хязгаарлалттай" дүгнэлт гаргаж, тайланг 2025 оны 6 дугаар сард Улсын Их Хуралд хүргүүлсэн. Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн УИХ-д 1 асуудлыг толилуулж, Ерөнхий сайдад 6, Эдийн засгийн хөгжлийн сайдад 3, Сангийн сайдад 3 зөвлөмжийг тус тус хүргүүлсэн. Зөвлөмжийн хэрэгжилтэд хагас жил тутамд хяналт тавьж, дүнг аудитын тайланд тусган тайлагнадаг.

Гурав. Улсын нэгдсэн төсөв дэх хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, худалдан авах ажиллагаа, гадаад зээл, тусламж, хандив, санхүүгийн дэмжлэгийн төлөвлөлт, гүйцэтгэл, ашиглалт, зарцуулалт, хэрэгжилт, тайлагнал дахь нийтлэг гол алдаа, тэдгээрийг дахин давтахгүй байх үүднээс хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Төрийн аудитын байгууллага хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд 2023-2024 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, худалдан авах ажиллагаа, гадаад зээл тусламж, хандив, санхүүгийн дэмжлэгийн төлөвлөлт, гүйцэтгэл, ашиглалт, зарцуулалт, хэрэгжилт, тайлагналтай холбоотой асуудлаар дараах гүйцэтгэлийн болон нийцлийн аудитыг гүйцэтгэж, аудитын тайлан, дүгнэлтийг Улсын Их Хурал, Засгийн газар болон холбогдох байгууллагуудад тус тус хүргүүлсэн.

Хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ: Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.8, 9 дүгээр зүйлийн 9.1-д заасны дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн төсөл болон нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, худалдан авах ажиллагаанд хийсэн аудитаар дараах нийтлэг алдаа, зөрчил илэрч байна. Тухайлбал:

- Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгах, санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдуулж төлөвлөөгүйгээс нь төсөл, арга хэмжээний хэрэгжилт удаашрах, төсөвт өртөг нэмэгдсэн;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барихаар төлөвлөсөн барилга байгууламжийн 52.8 хувь нь магадлалаар баталгаажсан зураг төсөвгүй, зарим төсөл арга хэмжээний үндсэн барилгын ажлын даалгавар, зураг төсөл, төсвийг бүрэн боловсруулж батлуулаагүй, барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх хүний нөөц хангалтгүй байгаагаас магадлалын дүгнэлт гаргах ачааллыг нэмэгдүүлж, дүгнэлт чанаргүй болох эрсдэлийг үүсгэсэн (2023-2024 онд);
- Тухайн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг бодлогын баримт бичигтэй уялдуулж төлөвлөөгүй, хэрэгжүүлэхээр баталсан зарим төсөл, арга хэмжээ нь улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаагүй, техник, эдийн засгийн үндэслэл, үр ашгийн тооцооллыг хийгээгүй;
- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, Засгийн газрын тусгай сан, хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төрөл, төсөвт өртгийн ялгаа зааг, ач холбогдол тодорхойгүй байгаа нь санхүүгийн нөөцийг үр дүнгүй зарцуулахад хүргэсэн;
- Тайлант хугацаанд хэрэгжиж дууссан зарим төсөл, арга хэмжээний үр дүнд үүссэн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн тоног төхөөрөмжийн ашиглалт, захиалагчийн хяналт хангалтгүй, гүйцэтгэлийн чанарт сөргөөр нөлөөлсөн;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг барилга, угсралтын ажлыг гүйцэтгэх салбарын чадамж, дотоодын барилгын материалын үйлдвэрлэлийн хүчин чадалтай уялдуулаагүй, нэг дор хэт олон арга хэмжээг зэрэг хэрэгжүүлж байгаа нь төсөвт өртөг нэмэгдэх сөрөг үр дагаврыг бий болгосон.

Аудитаар илрүүлсэн алдаа зөрчил, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг эрх бүхий албан тушаалтан, холбогдох байгууллагад өгч, хэрэгжилтэд давтан аудит хийх байдлаар хяналт тавьж байна.

Төрийн аудитын байгууллагаас 2023-2024 онд улсын төсвөөс санхүүжүүлэхээр Төсвийн тухай хуульд тусгаж баталсан төсөл, арга хэмжээний төсөвт өртгийн нэмэгдэл зардлын шалтгаан нөхцөлийг тодруулж, дүн шинжилгээ хийн, дүгнэлт гаргахад дараах алдаа зөрчил илэрч байна. Тухайлбал:

- Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаснаас нэмэлт зардал гарч, төсөвт ачаалал үүсгэсэн;
- Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа магадлалаар баталгаажсан зураг төсөлд үндэслэхгүй байгаа нь тендерт шалгарсан компанид давуу байдал бий болгосон.

Аудитын үр дүнд үндэслэн эрх бүхий байгууллага, албан тушаалтанд аудитаар илрүүлсэн алдаа зөрчлийг арилгах талаар холбогдох зөвлөмжийг өгч, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллаж байна. Үүнд:

- Барилга байгууламжийн эдийн засаг, төсөв, үнэ бүрдлийн норм, нормативын баримт бичгийг олон улсын стандартад нийцүүлэн шинэчлэх ажлыг эрчимжүүлэх, төсөвт өртгийг тооцох, магадлал хийх тогтолцоог үнэлэх, магадлал хийх үйл ажиллагаанд хяналт хийж, иргэн, хуулийн этгээдийн магадлал хийх эрх олгох үйл ажиллагаанд тэгш өрсөлдөөнийг бий болгох;
- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилт, төсөвт өртөгт дотоод аудитыг тогтмол гүйцэтгэж, хэрэгжилтийг тайлагнадаг байх зэрэг зөвлөмжийг өгч, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Барилга байгууламжийн зураг төсөл, төсөвт өртгийн тооцоог гүйцэтгэж байгаа инженер, төсөвчин, экспертүүдийн ур чадварыг сайжруулах, ёс зүйн хариуцлагыг өндөржүүлэх шаардлагатай. Мөн аудитаар төсөл, арга хэмжээг төлөвлөх шатанд Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль, журам жил бүр зөрчигдөж байгаа шалтгааныг тодруулан үүсэж байгаа үр дагаврыг арилгахад дэмжлэг үзүүлэх хууль, эрх зүйн шинэчлэл хийх нь зүйтэй юм.

Гадаадын зээл, тусламж: Үндэсний аудитын газраас “Засгийн газрын шугамаар хандивлагч орон, олон улсын байгууллагаас авсан зээл, тусламжийн ашиглалт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитыг 2021 онд, “Хөдөө аж ахуйн салбарын зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж” сэдэвт гүйцэтгэлийн аудитыг 2023 онд тус тус хийсэн. Эдгээр гүйцэтгэлийн аудитаар гадаад зээлийн бодлого, хэрэгжилт, хяналт, тайлагнал, үр нөлөөтэй холбоотой дараах алдаа зөрчлийг илрүүлсэн. Тухайлбал:

- Өрийн удирдлагын тухай хуульд заасны дагуу Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого, зорилттой уялдуулсан гадаад зээлийн талаар баримтлах бодлогыг батлуулаагүй;
- Гадаад зээлийн хөрөнгийг дотоодод дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулахдаа зээлийн эргэн төлөлтөд тавих хяналт болон хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах ажлыг зохион байгуулах чиг үүргээ бүрэн хэрэгжүүлдэггүйгээс нийт зээлийн 47.0 хувь нь эргэн төлөгдөөгүй;
- Гадаад тусламжаар хэрэгжүүлж байгаа зарим төслийг төсвийн багцад тусгаагүйгээс ашиглалтын дүнг бүртгэдэггүй, тайлагнадаггүй, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийдэггүй нь улсын төсвийн хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэрээс төслийг давхар санхүүжүүлэх эрсдэл үүссэн.
- Засгийн газрын гадаад зээл, тусламжийн ашиглалтын мэдээллийг Шилэн дансны тухай хуулийн дагуу цахим хуудсанд бүрэн байршуулж, иргэд, олон нийтэд мэдээлээгүй;
- Хөдөө аж ахуйн салбарт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилт удааширсан, зогссон, зориулалт өөрчлөгдсөн зэрэг нь зээлийн ашиглалтыг үр дүнгүй болгоход нөлөөлсөн;
- Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэл, тооцоо судалгаагүй, төлөвлөлтийн шалгуур хангаагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн;
- Дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлтийг Монгол банкнаас баталсан банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур хангаагүй арилжааны банканд төвлөрүүлсэн.

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2024 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2025 оны А/108 дугаар тушаалыг тус тус үндэслэн Үндэсний аудитын газраас “Хөдөө аж ахуйн салбараас бусад салбарт хэрэгжүүлсэн гадаадын зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөт байдалд аудит хийж байна.

Төрийн аудитын байгууллагаас аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн эрх бүхий байгууллага, албан тушаалтанд алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх талаар дараах зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг чиглэн болгож, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилт, удирдлагын нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, төслийн хэрэгжилт, үр дүнд тавих хяналтыг сайжруулах хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай юм. Тухайлбал:

- Дамжуулан зээлдүүлсэн эргэн төлөлт хийгдээгүй зээлийг барагдуулах ажлыг үр нөлөөтэй зохион байгуулах хяналтын механизмыг бүрдүүлж ажиллах;

- Гадаад зээлийн хөрөнгийг хөгжлийн бодлого, түүний зорилттой уялдуулж, эдийн засаг, нийгмийн үр ашигтай төсөлд зарцуулж, үр өгөөжийг нэмэгдүүлэх, хуулийн шаардлага хангахгүй, эрсдэлийн үнэлгээ хийгээгүй төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх;
- Гадаад зээлийн ашиглалтыг сайжруулж, гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн үр нөлөөт байдалд үнэлгээ хийж, үр дүн, хариуцлагын тогтолцооны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох.

Төрийн аудитын байгууллагаас хуульчилсан болон бодлого, стратегийн түвшинд гүйцэтгэж буй улсын төсвийн хөрөнгө оруулалт, худалдан авалт, гадаад тусламжийн хэрэгжилтэд алдаа, дутагдлууд нийтлэг байдлаар давтан илэрч байгаа нь шалгагдагч болон холбоотой талууд төрийн аудитын шийдвэрийн биелэлтэд ач холбогдол өгөхгүй байгаагаар илэрч байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээнд Төрийн аудитын байгууллагын бие даасан, хараат бус байдлыг баталгаажуулах эрх зүйн орчныг сайжруулах, санхүүгийн тогтолцоог бэхжүүлэх, аудитын үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх чиглэлээр бодлогын түвшинд дэмжлэг авахад УИХ болон Таны дэмжлэг хэрэгтэй болохыг тэмдэглэж байна.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР